



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/03

Алтай хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед
зохион байгуулалтын арга хэмжээ авах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь хэсэг, Улсын онцгой комиссын 2022 оны 01 дүгээр хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг спорт заал, фитнес, усан бассейн, баар, караоке, билльярд, цахим тоглоом, паб-ын үйл ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 01 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал хугацаанд бүрэн зогсоож, нийтийн хоол үйлдвэрлэл, рестораны үйл ажиллагааг 09:00-22:00 цагийн хооронд явуулахыг зөвшөөрсүгэй.

2.Олон нийтийг хамарсан хурал цуглаан, танхимын сургалтыг 50 хувийн дүүргэлттэй зохион байгуулж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан голомтын эцсийн халдваргүйтгэлийг хийж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвд тус тус үүрэг болгосугай.

4.Аймгийн хэмжээний ундны усанд итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийхэд шаардлагатай 1,776,600 (нэг сая долоон зуун далан зургаан мянга зургаан зуу) төгрөгийг Гамшгийн сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР